



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 5/11

Жаргалант

Түр орлон гүйцэтгэгч томилох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.1.1 дэх заалт, 43 дугаар зүйлийн 43.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Засаг даргын Тамгын газрын дарга Халтар овогтой Баасансүрэн нь 2025 оны 08 дугаар сарын 25-ний өдрөөс ээлжийн амралтаа авч байгаа тул ээлжийн амралт дуусах 09 дүгээр сарын 22 ны өдөр хүртэл Нийгмийн бодлогын мэргэжилтэн Г.Тэргэлийг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгүүлсүгэй.

2. Х.Баасансүрэн, Г.Тэргэл нарын ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Комиссын дарга Э.Ононцэцэг– Санхүү албаны дарга

Нарийн бичиг Б.Сумъяа- Төрийн сангийн мэргэжилтэн

Гишүүн Г.Анхзаяа – Хүүхэд гэр бүрийн нийгмийн ажилтан

3. Ажлыг чанартай гүйцэтгэж акт тэмдэглэл хөтөлж ажиллахыг комиссын нарийн бичиг (Б.Сумъяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ